

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛДАГ ТӨРИЙН БУС
БАЙГУУЛЛАГУУДЫГ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД
ОРОЛЦОХЫГ УРЬЖ БАЙНА**

2025.05.09

Чингэлтэй нэгдсэн эмнэлгийн Төлөөлөн удирдах зөвлөлд Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагыг төлөөлөх гишүүний сонгон шалгаруулалтад оролцохыг урьж байна.

Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтэй Төрийн бус байгууллагын нэр дэвшигч нь Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 15.1, 15.26 дахь хэсэгт заасан шалгуур, шаардлагыг хангасан, 15.24.2.-т заасан чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Төрийн бус байгууллага байх бөгөөд дараах баримт бичгийг бүрдүүлж ирүүлнэ. Үүнд:

1. Төрийн бус байгууллагаас тухайн иргэнийг Чингэлтэй нэгдсэн эмнэлгийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд ажиллах олон нийтийн төлөөллийн сонгон шалгаруулалтад оролцуулахаар нэр дэвшүүлж байгаа тухай тодорхойлолт (тодорхойлолтод Төрийн бус байгууллагын үйл ажиллагааны зорилго, чиглэлийн талаар товч дурдсан байна);
2. Боловсролын диплом, гэрчилгээ, үнэмлэхний хуулбар, мэргэшлийн зэргийн үнэмлэх эсхүл мэргэшүүлэх сургалтад хамрагдсан диплом, гэрчилгээ, үнэмлэхний хуулбар, нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар;
3. Нэр дэвшүүлж буй Төрийн бус байгууллагаас сүүлийн 6 сард нийгмийн даатгалын шимтгэл төлсөн талаарх нийгмийн даатгалын байгууллагын лавлагаа; (НД-7 маягт)
4. Нэр дэвшүүлж буй Төрийн бус байгууллагаас сүүлийн 6 сард татвар төлсөн талаарх татварын байгууллагын тодорхойлолт;
5. Төрийн бус байгууллагаас нэр дэвшүүлж буй иргэн нь улс төрийн намын удирдах, орон тооны болон сонгуульт ажил эрхэлдэггүйг баталгаажуулж бичсэн баталгаа (нэр дэвшигчийн өөрөө бичиж баталгаажуулсан өргөдөл байна);
6. Хуулийн этгээдийн үүсгэн байгуулагчийн талаарх лавлагаа;
7. Ашиг сонирхлын зөрчлийн мэдэгдэл, тайлбар /Нэр дэвшигч нь Авлигатай тэмцэх газрын даргын 2024 оны А/96 дугаар тушаалын 3 дугаар хавсралт/;
8. Төрийн бус байгууллага нь бусад төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгийн Төлөөлөн удирдах зөвлөлд төлөөлөл нь томилогдоогүй болохыг нотолсон тодорхойлолт /төрийн бус байгууллагын албан бичиг дээр гарсан байх/;

Сонгон шалгаруулалтад оролцогчийн материалыг 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 17:00 цаг хүртэл цаасан хэлбэрээр /битүүмжлэгдсэн байх/ баримт бичгийг хүлээн авна.

Материал хүлээн авах газар:

Чингэлтэй дүүрэг 4-р хороо, Нийслэлийн засаг захиргааны III байр /Нийслэлийн Эрүүл мэндийн газар/ 2 давхарт 207 тоот өрөө Г.Энхзул мэргэжилтэн, холбогдох утасны дугаар 77990101- 1-2

Жич:Хуурамч баримт бичиг бүрдүүлсэн тохиолдолд хариуцлагыг тухайн Төрийн бус байгууллага хүлээнэ.

“СОНГОН ШАЛГАРУУЛАХ ХОРОО”

ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬ

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ЭМНЭЛГИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

15 дугаар зүйл. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох, түүнд тавих шаардлага

15.1.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн дараахь шалгуурыг хангасан байна:

15.1.1.тухайн эмнэлэгтэй ашиг сонирхлын зөрчилгүй;

15.1.2.нийгмийн эрүүл мэнд болон анагаах ухааны боловсролтой, эсхүл эрх зүй, эдийн засаг, удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр мэргэшсэн, эрүүл мэндийн салбарт ажилласан туршлагатай байх;

15.1.3.улс төрийн намын удирдах, орон тооны болон сонгуульт ажил эрхэлдэггүй;

15.1.4.бусад эрүүл мэндийн байгууллагад хөрөнгө оруулалт хийгээгүй.

15.24.2.эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагын төлөөллийг сонгох;

15.26.Төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөлийн олон нийтийн төлөөлөлд нэр дэвшүүлэх төрийн бус байгууллага дараахь шаардлагыг хангасан байна:

15.26.1.сүүлийн зургаан сараас дээш хугацаанд тасралтгүй үйл ажиллагаа явуулсан;

15.26.2.тухайн эмнэлэгтэй ашиг сонирхлын зөрчилгүй;

15.26.3.санхүүгийн зөрчилгүй.